


ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИД БАР КОД АВАХ

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр байгаль орчинд ээлтэй, гарал үүсэл нь тодорхой эргэн мөшгөх боломжтой түүхий эдээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүсдэг болсон. Дэлхий нийтийн энэхүү хандлагатай холбоотойгоор малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэр хүнд, үнэлэмжийг өсгөхийн тулд Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон-Алт малын эрүүл мэнд төсөл, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ), Мал эмнэлгийн ерөнхий газар, Монголын ноос, ноолуурын холбоо, Монголын арьс ширийн холбоотой хамтран “Хариуцлагатай нүүдэлчид” мөшгөх системийг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн хөгжүүлж байна (Зураг 1).



Зураг 1. “Хариуцлагатай нүүдэлчид” мөшгөх систем

Энэхүү систем нь бэлчээрийн төлөв байдал, малын тавлаг байдал, эрүүл мэнд, түүхий эдийн чанар, хүрээлэн байгаа байгаль орчинд ээлтэй зэрэг үзүүлэлтүүдийг цогцоор багтаахын зэрэгцээ малчдаас авах малын гаралтай түүхий эдийн тогтвортой, хариуцлагатай байдлыг стандартчилах, хэрэглэгчдэд бүтээгдэхүүний түүхийг мэдэх боломжоор хангах юм.

Хариуцлагатай нүүдэлчид систем нь ХХААХҮЯамны МЭЕГ-аас хөгжүүлж буй мал эмнэлэг, сүлжээ лабораторийн систем, мал эмнэлгийн гэрчилгээний систем, малын бүртгэлийн систем, ГЗБГЗЗГ-ын газрын кадастрын мэдээллийн систем, газрын мониторингийн систем, зэрэг улсын хэмжээний мэдээллийн системүүдтэй холбогдсон.



Зураг 2. “Хариуцлагатай нүүдэлчид” мөшгөх системийн бааз

Энэхүү системд мал, мах бэлтгэн нийлүүлэлтийн бүхий л оролцогч талууд (хоршоо, боловсруулах үйлдвэр, экспортлогч байгууллага) өөрсдийн хэрэглээнд тохирсон эрхээр нэвтрэх боломжтой юм. Түүхий эдийг анхан шатанд бэлтгэн нийлүүлж буй хоршоод, аж ахуйн нэгж байгууллага нь нийлүүлж буй түүхий эдийнхээ гарал үүсэл, хэмжээ, чанарын талаарх мэдээллийг энэхүү системд оруулснаар түүхий эд худалдан авагчдад чанарын баталгаа олгох, гарал үүслийн эргэн мөшгөх тогтолцоог нэвтрүүлэх суурь болно. Хоршоод боловсруулах үйлдвэр болон экспортлогч байгууллагуудад нийлүүлж буй түүхий эдийнхээ шилжүүлгийг цахимаар хийх ба шилжүүлгийн мэдээлэлд гарал үүслийн гэрчилгээ, QR код дагалдана. Энэхүү QR кодыг боловсруулах үйлдвэрүүд, экспортлогч байгууллагууд нь гар утасны аппликейшин ашиглан худалдан авч буй түүхий эдийнхээ гарал үүслийн мэдээллийг авах, эргэн мөшгөх боломжтой болох юм.

